

ДАЯАРШЛЫН ҮЕД ӨВӨР МОНГОЛЫН ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Geriletu*, D. Enkh-Otgon**

Хураангуй: 2003 оноос хойш БНХАУ-ын үхрийн махны импортийн хэмжээ өндөр хурдацтай өсөж, өнөөдрийн байдлаар БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ нь дэлхийн хоёр дахь том үхрийн мах импортлогч улс болгосон байна.

Тоо баримтаас авч үзвэл БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ нь 1980-аад оны эхэн үед нэг хүнд ноогдох махны импорт 0.1-0.2 кг байсан бол өнөөдөр 5.5 кг болж өссөн, 2003 онд үхрийн махны нийт импорт 15 сая доллар байсан бол 2016 онд 2.6 тэрбум АНУ долларт хүрч, импортийн хэмжээ нь 579,800 тонн хүрчээ.

Цаашид ч үндэстний цөөнхийн хэрэглээнээс, бүх иргэдийн хэрэглээ, бүс нутгийн хэрэглээнээс, улс даяарх хэрэглээ болон өсөн нэмэгдэж, БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ нь үргэлжлэн өсөх хандлагатай байна. 2017 онд үхрийн мах үйлдвэрлэлээрээ дэлхийд хоёрдугаарт ордог АНУ-ын мах үйлдвэрлэгчид БНХАУ-ын зах зээлд нэвтэрч, үхрийн махны зах зээлд өрсөлдөөнийг улам бүр эрчимжүүлсэн байна. АНУ-ын мах үйлдвэрлэгчид БНХАУ-ын зах зээлд нэвтэрч байгаа нь Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлд ямар нөлөө үзүүлэх вэ? Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл болон АНУ-ын үхрийн махны үйлдвэрлэл, боловсруулалт, бүтээмжийн талаар харьцуулсан судалгаа хийж, даяаршлын эрин үед уламжлалт, үр ашиг муутай үйлдвэрлэл, менежментийн горимоос хэрхэн яаж орчин үеийн арга технологи, менежментийн горимоор хөгжүүлэх боломж байгааг тус өгүүлэлд тусгахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: БНХАУ-ын үхрийн махны зах зээл, Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл, АНУ-ын үхрийн махны үйлдвэрлэл

Abstract: China's beef import has been grown up rapidly since 2003, and the dramatically increased beef consumption has made China the world's second largest beef importer. Statistically, now China beef import has become 5.5kg per person while it was 0.1-0.2kg in early 1980s. Similarly, beef import has been increased to US \$2.6 billion by 2016 while it was only US \$15 million in 2003, and beef import amount is now totalling 579,800 tonnes. As per the forecast, this beef consumption increasing trend will continue ramping up as the minorities' consumption will become whole nation's, and regional's to nationwide. As per the forecast, this beef consumption increasing trend will continue ramping up as the minorities' consumption will become whole nation's, and regional's to nationwide. In

* МУИС, Бизнесийн сургууль, докторант (E-mail) 595388448@qq.com

**МУИС, Бизнесийн сургууль, дэд профессор enkhogon@num.edu.mn

2017, the US beef producers, the second largest in the world, has penetrated into China market and accelerated competition in the market. What impact the USA beef producers will bring to Inner Mongolian beef production? The research on Inner Mongolia beef production and comparative analysis of beef production, processing and productivity in the United States is intended to illustrate how the traditional and inefficient production and management regimes of globalization can be developed through modern technology and management practices.

Key words: Beef market in China, beef production in Inner Mongolia, beef production in the USA


Нэг. Глобалчлалын үе дэх БНХАУ-ын үхрийн махны зах зээл ба Өвөр Монголд үхрийн махны үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө

1. БНХАУ-ын үхрийн махны зах зээл

2017 оны 5-р сарын 12-нд БНХАУ-ын Төрийн Худалдааны яамнаас АНУ-ын үхрийн махыг зах зээлдээ 14 жилийн дараа дахин орох болсныг зарласан байна. 2003 онд АНУ-ын үхрийн махыг хориглосноос хойш 14 жилийн дараа БНХАУ-ын үхрийн махны зах зээлд асар том хомсдол гарсан нь АНУ-ын үхрийн махыг БНХАУ-ын үхрийн махны зах зээлд дахин орох чухал шалтгаан болсон юм.

БНХАУ-д үхрийн махны хэрэглээ 1980-аад оны эхэн үетэй харьцуулахад нэг хүнд ноогдох махны импорт 0.1-0.2 кг байсан бол өнөөдөр 5.5 кг болж өссөн, 2003 онд үхрийн махны нийт импорт 15 сая доллар байсан бол 2016 онд 2.6 тэрбум ам.долларт хүрч, импортийн хэмжээ нь 579,800 тонн хүрчээ.

Зураг 1. БНХАУ-ын нэг хүнд ноогдох үхрийн махны хэрэглээ /кг/




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний Статистикийн хороо

БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ нь үндэстний цөөнхийн хэрэглээнээс, бүх иргэдийн хэрэглээ, бүс нутгын хэрэглээнээс, улс даяарх хэрэглээ болон өсөн нэмэгдэж, БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ нь үргэлжлэн өсөх хандлагатай байна. 2017 онд үхрийн мах үйлдвэрлэлээрээ дэлхийд хоёрдугаарт ордог АНУ-ын мах үйлдвэрлэгчид БНХАУ-ын зах зээлд нэвтэрч, үхрийн махны зах зээлийн өрсөлдөөнийг улам эрчимжүүлсэн байна. Ийм учраас БНХАУ-ын үхрийн махны зах зээлийн импортын хэмжээ ойрын жилүүдэд ихээхэн өөрчлөлт гарсан байна. Статистикийн мэдээгээр 2017 онд БНХАУ импортын үхрийн мах 700,000 тонн, жилийн өсөлт 19.9%,

мөнгөн дүнгээр 3.07 тэрбум ам.долларт хүрч, 21.8% -иар өссөн байна. Үүнийг импортлогч гол улсуудаар авч үзвэл: Уругвай 200,000 тонн, 28%; Бразил 200,000 тонн, 28%; Австрали 120,000 тонн, 17%; Аргентин улсаас 90,000 тонн, 12% Шинэ Зеланд 80,000 тонн, 11%; бусдыг нь АНУ, Канад, Чили улсаас тус импортолсон байна.

Зураг 2. Хятадын үхрийн махны импорт, экспортын байдал (мян.тонн)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний Статистикийн хороо

Үхрийн махны импортийн хэмжээ ийн нэмэгдэхийн хэрээр БНХАУ-ын үхрийн махны салбарын өнөөгийн байдал ямар байна вэ? нэн ялангуяа Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлд ямар нөлөө үзүүлж байна вэ? гэдэг нь чухал асуудал болоод байна.

2. Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлийн оноогийн байдал

Өвөр Монгол нь БНХАУ-ын хойд хил дээр байрладаг, 118 мянган километр газар нутаг бүхий нийт газар нутгийн 12.3 хувийг эзэлдэг. Зүүн хэсэгтээ Дорнод далайд ойрхон байрлах ба баруун хэсэг нь хуурай газар нутаг голлосон байдалтай байна. Зүүнээс баруун тийшээ бэлчээрийн байдал, нөхцөл нь нойтон, хагас чийглэг, хагас хуурай газар нутаг бүхий нуга талын бүс, цөлөрхөг хээрийн бүс нутгуудтай.

Өвөр Монголын мал аж ахуй нь эртнээс уламжлагдсан нүүдлийн мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн болон менежментийн үндсэн загвартай.

Нүүдлийн менежментийн загвар нь малчид нутгийн газар зүй, цаг уурын нөхцөл, бэлчээрийг хөгжүүлэх онцлогт тулгуурлан малаа бэлчээж, ус, өвс гэжээлтэй уялдуулан нүүдэллэн бэлчээдэг онцлогтой.

Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл нь БНХАУ-ын зүүн хойд хэсгийн нутгийн бүс нутагт хамаарагдах бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд үхрийн махны үйлдвэрлэлийн эрэлтийг нэмэгдүүлж, илүү хурдацтай хөгжих нөхцлийг бүрдүүлж байна.

2017 онд Өвөр Монголын мал аж ахуйн статистикийн мэдээгээр нийт бүс нутгийн малын тоо 126 сая толгой, мах бэлтгэлийн хэмжээ нь 2.767 сая тонн байсны дотор үхрийн махны үйлдвэрлэлийн хэмжээ 595,000 тонн буюу өмнөх жилээсээ 7.0% -аар өссөн байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд БНХАУ-тай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан улсуудын импорт нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаадын малын гаралтай бүтээгдэхүүн дотоодын зах зээлд орж ирэн, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ дотоодын ижил төстэй бүтээгдэхүүнүүдээс доогуур байж, дотоодын мал аж ахуйд үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдсээр байна. Тухайлбал, Өвөр Монголын амьд малын худалдан авалтын үнэ 2014 болон 2015 онуудад хоёр жил дараалан буурч, үйлдвэрлэлийн өртөг өндөр хэвээр байхад малчдын орлогын өсөлт нь буурсан байна (Han Chengfu, Nancheng-fu 2016).

Хүснэгт 1. 2013-2017 онд Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлийн хэмжээ (мян.толгой)

	2013	2014	2015	2016	2017
Үхрийн тоо	612.43	630.60	670.96	654.86	656.7

Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний Статистикийн хороо

(3) Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлийн гол онцлог

Өвөр Монгол нь нийт 86.667 сая га, 1000 гаруй төрлийн тэжээлийн ургамал бүхий өргөн уудам талбайтай бөгөөд бэлчээрийн нөөц баялаг нь мал өсгөхөд тохиромжтой. Тухайлвал: Өвөрмонголын ихэнх нь БНХАУ-ын хөдөө аж ахуйд чухал ач холбогдолтой эрдэнэ шишийн бүтээмж бүхий агро-бэлчээрийн экологийн бүсэд оршдог бөгөөд газар тариалангийн нөөц баялагтай, үхрийн аж ахуйг хөгжүүлэх үндэс суурийг тавьж өгсөн:

1. Бэлчээрийн үхрийн өсөлт нь тариалангийн аж үйлдвэрлэлтэй холбоотой. Энэ нь мал аж ахуйн гаралтай тэжээлийн нөөц нэмэгдсэн ба үхрийн мах нь өндөр үр өгөөжтэй, биеийн дундаж жин бусад бүс нутгаас өндөр байдаг. Бүс нутгийн үхэрт олон төрлийн үүлдэр байдаг ба монгол үхэр, шинэ үхэр, бэлчээрийн улаан үхэр, таван том үхэр гэх мэт үүлдрийн сүргүүд байдаг.
2. Өвөр Монголын мал аж ахуй нь уламжлалт нүүдлийн мал аж ахуйн

загвартайгаа байсаар байна. Иймд газар зүй, үйлдвэрлэлийн хувьд тархай бутархай оршиж, эрчимжсэн мал аж ахуйн шинэ үйлдвэрлэлийн талаас харахад технологи, мэргэшил хоцрогдсон шинжтэй. Өвөр Монголын мал аж ахуй нь үйлдвэрлэлийн хувьд:

- Үйлдвэрлэлийн харилцан холбоо бүхий системжилт муу
 - Үйлдвэрлэлийн механикжуулалт багатай
 - Бүтээгдэхүүний чанар харилцан адилгүй, тодорхой стандарт байхгүй
 - Үйлдвэрлэлийн дэд бүтэц зэрэг кластержилт байхгүй
 - Үйлдвэрлэлийн зардал ихтэй байгаа нь үхрийн махан бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварт шууд нөлөөлж байна.
3. Өвөр Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн боловсруулалтын байдал нь уламжлалт арга барилтайгаа байсаар байна. Тухайлбал 2017 оны байдлаар Өвөр Монголын махны үхрүүдын 2/3 нь Өмнөд БНХАУ-ын худалдааны зах зээлд Амьд үхэр хэлбэрээр борлуулагдаж байна. Энэ нь, Өвөр Монголын мал өсгөсөн урт түүхтэй холбогдох боловч Өвөр Монголын үхрийн махны урт хугацааны худалдааны аргачлал, ялангуяа үхрийн аж ахуйг хөгжүүлэхэд голлон анхаарч ирсэн амьд үхрийн худалдаатай шууд холбоотой.
4. Өвөр Монголын зүүн хэсэгт үхрийн үржүүлгийн газар нутаг аажмаар хөгжин, мэргэшсэн малын арилжааны зах зээлийг бий болгосон. Өвөр Монголд амьдаар борлуулдаг үхрийн зах зээл голчлон Тонглио хот, Чифенг хот, Хилин гол лигийн урд талд таван хошуунд төвлөрдөг. Худалдааны 26 томоохон арилжааны зах зээл байдаг бөгөөд тус бүр нь жилд дунджаар 50,000-3300,000 толгой арилжаалдаг бөгөөд ихэвчлэн 80,000-аас 100,000 толгой үхэр арилжаалдаг. Худалдааны үхрийн хүндийн жин 400-600 кг хооронд хэлбэлздэг. (БНХАУ-ын үхэр үржүүлгийн дүн шинжилгээ, 2017)

Хоёр. Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах зарим санал

Өвөр Монголын үхрийн махны аж үйлдвэрлэл нь хялбар, байгалийн аж үйлдвэрлэлийн хэлбэрээсээ технологид суурилсан аж үйлдвэржилтийн хэлбэр лүү шилжих шаардлагатай тулгараад байна.

АНУ нь өнөө цаг үед дэлхийн үхрийн махны зах зээлд техник, технологи, бүтээмжээрээ ноёлж буй улс юм, Иймээс Өвөр Монголын үхрийн махны аж үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах үүднээс АНУ-ын үхрийн махны аж үйлдвэрлэлийн үйл явцтай харьцуулан харуулъя.

Хүснэгт 2. АНУ-ын үхрийн махны үйлдвэрлэлтэй харьцуулсан байдал

Төрөл зүйл	АНУ-ын үхрийн махны үйлдвэрлэл	Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл
Кластержилт	Үйлдвэрлэлийн кластержилт сайн хөгжсөн	Үйлдвэрлэлийн кластержилт муу хөгжсөн, тархай бутархай
Бүтээмж	Үйлдвэрлэлийн бүтээмж өндөр	Үйлдвэрлэлийн бүтээмж муу
	Хөдөлмөрийн бүтээмж өндөр, ашиглалт их	Хөдөлмөрийн бүтээмж муу, ашиглалт бага
	Үйлдвэрлэлийн гарц сайн	Үйлдвэрлэлийн гарц муу
Техник, технологи	Үйлдвэрлэлийн техник, технологи сайн	Үйлдвэрлэлийн техник, технологи маш муу
	Ажиллагсдын техник, технологийн мэргэшил, мэдлэг сайн	Ажиллагсдын техник, технологийн мэргэшил, мэдлэг муу
	Техник, технологийн дэвшил сайн нэвтэрдэг	Техник, технологийн дэвшил муу нэвтэрдэг, чадамж муу, үйлдвэрлэлийн чадвар тааруу
Чанар	Үхрийн үүлдэр сайн	Үхрийн үүлдэр дунд
	Тэжээл, арчиллага сайн	Тэжээл, арчиллага муу

Эх сурвалж: Судлаачдын харьцуулалт

Дээрх харьцуулалтаас гадна дараах хүчин зүйлс АНУ-ын үхрийн махны үйлдвэрлэлийг Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэлтэй харьцуулахад давуу талтай болгож байна. Үүнд:

1. АНУ-ын бүх үхрийн махны аж үйлдвэрлэлийн 25%-ийг томоохон компаниуд үйлдвэрлэж, үлдсэн хэсгийг бусад бага дунд компаниуд буюу малчдын тусгай нэгжид үйлдвэрлэж байгаатай харьцуулбал Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл нь малчид голлосон хувь хүн олонх тоог эзэлж үйлдвэрлэлийн шинэ технологи мэргэжил дутмаг, үйлдвэрлэх ур чадвар нь аж үйлдвэрлэлийн тогтолцоонд зохицох талаар тааруухан байж, ажлын бүтээмжид нөлөөлж, зардал ихсэж, бүтээгдхүүний зах зээлийн үнийг өндөр болгож байна. Өвөр Монголын өнөөгийн байдлаар үхрийн махны үйлдвэрлэлд дийлэнх нь малчид голлон эрхэлж байгаа бөгөөд олон өрхүүд тархай бутархай байдлаар аж ахуй эрхэлж, өрхийн хэдэн хүн цөөн тоо толгой малыг тэжээж байхад АНУ-д 250 мянган үхрийг 28 хүн малаж байдаг учраас үйлдвэрлэлий өртөг зардал нь асар их буурдаг.
2. АНУ-д эрдэнэ шиш тарих зардал тонн тутамд 800 юань байдаг бол БНХАУ-д эрдэнэ шиш тариалах зардал 2,400 юань байна. Иймээс Өвөр

- Монголын үхрийн махны зах зээл дахь үнэ өндөр байдаг нь гарцаагүй юм.
3. Мал аж ахуй үйлдвэрлэлийн технологи, мэргэжлийн талаар, шинэ технологийг ашиглах мэргэжил, үйлдвэрлэлийн ур чадвар, мэргэжил, машин, тоног төөрөмж дутмаг. Өвөр Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлийн төвлөрлийн хэмжээ бага, хүн бүрийн тэжээн арчилах үхрийн тоо бага боловч үйлдвэрлэлийн явцад мэргэжил, менежментийн талаар ойлголт, мэдлэг тааруухан байна. Иймээс үхрийн махан бүтэгдхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах талаар тоо хэмжээ бага, ашиглалт бага байдаг байна. АНУ-д үйлдвэрлэлийн ажилтан нэг хүн дунджаар 1200 толгой үхэр тэжээж байдаг бол БНХАУ-д нэг хүн дунджаар 80 толгой үхэр тэжээж арчилдаг байна. АНУ-д үхрийн нэг киллограмм жин нэмэгдүүлэхийн тулд 5.5 киллограмм хуурай тэжээл, бордоо зарцуулдаг бол БНХАУ-д 7 киллограмм тэжээл зарцуулдаг байна. Эдгээр тоо баримтууд нь Өвөр Монголд авч үзвэл хэт өндөр байж харьцуулахын аргагүй юм.
 4. Үхрийн махны чанарт нөлөөлөх хүчин зүйлд үхрийн махны тэжээл арчиллага, өвс бордоог зохистой тохируулах зэрэг үйлдвэрлэлийн менежментийн удирдлагын үйл ажиллагаатай холбогдолтойгоос гадна үхрийн үүлдэртэй шууд холбоотой байдаг. АНУ-ын үхрийн махны аж үйлдвэр нь АНУ-ын мал аж ахуйн салбарын хамгийн том үйлдвэрлэлийн салбар бөгөөд тухайн салбарын нийт бүтээгдэхүүний 25% -ийг эзэлдэг.
 5. АНУ-ын үхрийн махны үүлдрийн дотор Angus үхэр, Хадфорд үхэр, Брахман үхэр, Simmental үхэр, Charolais үхэр, гэгээн Гриффийн үхэр гэх мэт үхрийн үүлдэр байдаг бөгөөд үүлдэр бүрийн дотор тухайн үүлдрийн нийгэмлэг байж, үүлдрийн сайжруулт зэрэг ажлуудыг хариуцдаг. Ангус үхэр, Хадфорд үхэр зэрэг цэвэр үүлдрүүд нь эрлийз үүлдрийн үеийнхээс илүү бөгөөд үйлдвэрлэлийн гүйцэтгэл нь сайн, үр удмаа сайн зохицуулах чадвартай, хүнд жинтэй, махны өндөр гарцтай байдаг. Өвөр Монголын мал аж ахуйн үхрийн үүлдэрт монгол үхэр, шимэнтар үхэр зэрэг үүлдэр байдаг. Үүнд шимэнтар үхэр нь махны болон сүүний хосолсон үүлдэр байдаг ба монгол үхэр нь эрт үеэс нааш Монголын өндөрлөгт зохицож амьдарч ирсэн боловч одоо зах зээлийн өрсөлдөөнд тааруухан үүлдрийн төрөлд тооцогддог. Иймээс Өвөр Монголын үхрийн махны үүлдрийг өөрчилж сайжруулах нь чухал байна. Эдгээр харьцуулалт болон давуу, сул талын судалгаанууд дээр үндэслэн Өвөр Монголын үхрийн махны өрсөлдөх чадварыг сайжруулах дараах саналуудыг нэгтгэн дэвшүүлж байна.
1. Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл дахь технологийн түвшний сайжруулалт хийх. Өвөр Монголын мал аж ахуй нь эртнээс нүүдлийн

Үйлдвэрлэлд суурилж байсан учраас үхрийн махны аж үйлдвэр нь урт хугацаанд хаалттай салбар байсан бөгөөд гол үйлдвэрлэгчид нь малчид, гэр бүлийн хялбар менежментийн арга, ажиллагаа байсаар байна. Харин олон улсын үхрийн махны аж үйлдвэр нь эрчимсэн, технологид суурилсан аж ахуй эрхлэн бүтээмж өндөртэй үйлдвэрлэл эрхэлж буй нь өрсөлдөөний том давуу талыг үүсгэж байна. Тухайлбал АНУ-ын үхрийн махны аж үйлдвэр нь жил бүр хэдэн зуугаад мянган тоо толгой үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна. Энэ нь хөгжсөн улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн хэмжээ өндөр, зардал багатай, нэмүү өртөг өндөр ажиллаж байгаагаас шалтгаална.

Засгийн газрын зүгээс фермерүүдэд техникийн дэмжлэг, удирдамжийг бэхжүүлж, орчин үеийн мал аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. АНУ-ын үйлдвэрлэл, боловсруулалтын аж ахуйн нэгжүүд өндөр технологиор зах зээл рүү хөтөлж байгаагаас харвал Өвөр Монгол орны засгийн газраас орон нутгийн мал аж ахуйд нядалгаа, боловсруулалт, борлуулалтыг нэгтгэдэг тэргүүлэх аж ахуйн нэгжийг байгуулах нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, Чифенг хотод, Xilin Gol League болон бусад мал аж ахуй хөгжилтэй оронд тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон үйлдвэрлэлийн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэлийн стандартын загварыг бий болгох, нийлүүлэх тоног төхөөрөмж, техникийн үйлчилгээний систем, чанарын хяналтын систем, механикжуулалт үйл ажиллагааны үйлчилгээний системийг бий болгож, малчдын үйлдвэрлэх технологийг сайжруулах, үйлдвэрлэлийн нэгдсэн удирдлагыг бий болгож, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

2. Үхрийн махны үйлдвэрлэл дэх ажиллах хүчний асуудлыг зохицуулах. Ойрын жилүүдэд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг муугаас мал аж ахуй эрхлэгчдийн тоо, ажиллах хүч нь мал маллахаа байж хотод бусад ажил эрхэлсэн болсноос шалтгаалан мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөрийн хүч дутагдах байдал орж эхэлсэн байна. Үүнд зориулан засгын газраас малын үйлдвэрлэлийн амьдарлын орчныг сайжруулах, малжих үйлдвэрлэлийн ахицыг дэшлүүлэхэд анхаарч, их дээд сургуулийн оюутны малжих үйлдвэр рүү ажилд орох боломжийг дээшлүүлэх.
3. Үхрийн махны аж үйлдвэрлэлийн кластержилтыг хөгжүүлэх

Зураг 3. Өвөр Монголын үхрийн махны аж үйлдвэрийн кластержилт



Бизнес эрхлэгчид болон үхрийн махны гол үйлдвэрлэгч болох малчид хоорондын харилцааг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл явцыг стандартчлах зорилгоор үхрийн махны нийгэмлэгийг байгуулах. Мөн орон нутгын мал аж ахуйн нэгжүүдээс малыг худалдан авч, боловсруулах, борлуулах нэгдсэн үйлчилгээний том компанийг үүсгэн байгуулж, тэр нь үхрийн махны хоршоожилт болон зах зээлийг холбож, үйлдвэрлэлийн төвлөрөлийг сайжруулж, зардлыг багасган үр ашгийг дээшлүүлэх.

4. Үхрийн тэжээлийн бэлтгэл суурийг байгуулах. Үхрийн махны үйлдвэрлэлийг эдийн засгийн хувьд үр ашигтай байлгахын тулд үхрийн махны үйлдвэрлэлийн төвлөрөл тоо хэмжээг өсгөхийн зэрэгцээ тэжээлийн бэлтгэл суурийг сайн зохицуулах шаардлагатай. Нөгөө талаас, бид үйлдвэрлэлийн сүлжээг бэлчээр, тэжээлийн тариалалтаас эхлээд үхрийн махны боловсруулалт, борлуулалтаас эхлүүлэх, бүх үйл явцыг үр дүнтэйгээр холбох нь чухал. Өвөр Монголын үхрийн махны аж ахуйн байгалийн өвөрмөц давуу талыг ашиглан, орчин үеийн эрчимжсэн бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх, сүргийн бүтцийг зохицуулах, сортыг сайжруулан, хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуй хооронд уялдуулж эрдэнэ шишийн эко үрэл, ногоон дарш зэргийг бий болгон ашигласнаар бэлчээрийн ба хагас тэжээлийн мал аж ахуйг зохион байгуулах боломжтой.

Дүгнэлт

Дэлхий нийтийн даяаршлын цаг үед байгалийн аж үйлдвэрлэлийн явцаасаа салан технологийн аж үйлдвэржилтийн, бүтээгдэхүүний чанараар өндөр, зах

зээлийн өрсөлдөөнт чанараар өндөр аж үйлдвэрлэлийн орчинд Өвөр Монголын үхрийн махны аж үйлдвэрлэл нь хэрхэн өрсөлдөх чадвараа сайжруулж, хөгжих тухай доорх хэдэн санал дэвшүүлж байна. Үүнд:

- Өвөр Монголын үхрийн махны үйлдвэрлэл дэх технологийн түвшнийг сайжруулах үүднээс фермерүүдийн техникийн дэмжлэг, удирдлагыг сайжруулж орчин үеийн мал аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх
- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, засгын газраас орон нутгийн мал аж ахуйд нядалгаа, боловсруулалт, борлуулалтыг нэгтгэдэг тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг байгуулах
- Өвөр Монголын үхрийн махны аж ахуйн байгалийн өвөрмөц давуу талыг ашиглан, орчин үеийн эрчимжсэн бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх, сүргийн бүтэцийг зохицуулах,
- Үхрийн сортыг сайжруулан, хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуйг хооронд нь уялдуулж, эрдэнэ шишийн эко үрэл, ногоон дарш зэргийг гүйцэд ашиглан бэлчээрийн ба хагас тэжээлийн мал аж ахуйг идэвхитэй зохион байгуулах
- Мал маллах аж үйлдвэржилтийн үйлдвэрлэлийн үр ашгыг дээшлүүлэхэд анхаарахын зэрэгцээ ажиллагчдын амьдралын орчныг сайжруулах
- Их дээд сургуулийн оюутнуудыг малжих үйлдвэрлэл рүү ажил олгох боломжийг дээшлүүлж, орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх
- Орон нутгын мал аж ахуйн хөгжлийг нэгтгэн зангидсан бүтцийг бий болгож малчдын хоршоожилт, бүтээгдэхүүн боловсруулан худалдаалагч том компаниудыг нэгтгэн зангидах

Ашигласан материал

- [1] Nan Chengfu, Nancheng-fu “Өвөр Монголын Мал аж ахуйн Эдийн засгийн Хөгжлийн байдал ба хариу арга хэмжээний шинжилгээ” БНХАУ-ын Мал аж ахуйн сэтгүүл, 2016, 52 (6): 29-33
“БНХАУ-ын үхэр үржүүлгийн дүн шинжилгээ” БНХАУ-ын аж үйлдвэрийн мэдээллийн сан, 2017 он, www.chyxx.com20170815
- [2] 郑红. 草原的逻辑—牧区田野调查笔记, 民族出版社, 2018年
韩念勇. 草原的逻辑—草原生态与牧民生计调查报告民族出版社, 2018年
木村藤纪 アメリカの肉牛肥育と牛肉産業の徹底的研究 1985年 オールインワン出版部
- [3] Xiang Zi Li etc., “Current situation and future prospects for beef production in China — A review” Asian-Australas Journal of Animal Science, Vol. 31, No. 7:984-991 July 2018

- [4] National Animal Husbandry Service (1996-2016), Chinese Animal Husbandry Yearbook. Beijing, China: Chinese Agriculture Press; 2016.